

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны .. дугаар Улаанбаатар хот
сарын ...-ны өдөр

ЖОЛООЧИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Жолоочийн даатгалын тухай хуульд дор дурдсан агуулгатай хэсэг, заалтуудыг нэмсүгэй.

1/15 дугаар зүйлийн 15.4 дэх хэсэг:

“15.4.Даатгагч, жолоочийн даатгалын сан нь энэ хуулийн 15.2-т заасныг биелүүлээгүй нь даатгагч эсвэл жолоочийн даатгалын сангаас нөхөн төлбөр олгохоос татгалзах үндэслэл болохгүй.”

2/15 дугаар зүйлийн 15.5 дахь хэсэг:

“15.5.Даатгагч, жолоочийн даатгалын сан нь хохирогчийн эд хөрөнгө, эрүүл мэндэд учирсан хохирлыг нөхөн барагдуулахаар засвар, үйлчилгээ болон эрүүл мэндийн байгууллагыг санал болгож болно.”

3/ 15 дугаар зүйлийн 15.6 дахь хэсэг:

“15.6.Даатгагч нь цагдаагийн байгууллагаас даатгалын тохиолдолтой холбоотой бичлэг,авто тээврийн ослын бүртгэлийг гаргуулж авах эрхтэй.”

4/15 дугаар зүйлийн 15.7 дахь хэсэг:

“15.7.Жолоочийн даатгалын үйл ажиллагаа эрхлэгч нь энэ хуулийн 22.1.1-т заасан хөрөнгийг жолоочийн даатгалын санд шилжүүлэх үүрэгтэй.”

5/15 дугаар зүйлийн 15.8 дахь хэсэг:

“15.8.Жолоочийн даатгалын үйл ажиллагаа эрхлэгч нь энэ хуулийн 24.2-т заасан мэдээллийг хариуцлагын даатгалын мэдээллийн санд хүргүүлэх үүрэгтэй.”

6/17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсэг:

“17.2. Энэ хуулийн 17.1.2-т заасны дагуу хохирогч, даатгуулагч, даатгагч нь хохирлын хэмжээний талаар харилцан тохиролцоонд хүрээгүй бол даатгалын хохирол үнэлэгчийн дүгнэлтээр тогтоож болно.”

7/20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсэг

“20.3.Энэ хуулийн 20.2-т заасан буруутай этгээд нас барсан эсвэл төлбөрийн чадваргүй болох нь шүүхээр тогтоогдсон бол хариуцлагын даатгалын сангийн нөхөн төлбөрийг буцаан нэхэмжлэх эрх дуусгавар болно.”

8/22 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт:

“22.1.7. жолоочийн даатгалын санд төвлөрсөн хөрөнгийг банканд хадгалуулсан хүүгийн орлого.”

9/23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт:

“23.1.5.Энэ хуулийн 20.3-т заасан нөхцөл бүрдэж, сангаас олгосон нөхөн төлбөрийг буцаан нэхэмжлэх боломжгүй болсон хөрөнгө.”

2 дугаар зүйл.Жолоочийн даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “заасан этгээд нь” гэсний дараа “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэгт заасан” гэж, 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсгийн “даатгалын тохиолдол” гэсний дараа “даатгуулагчийн мэдүүлэг, хохирлын үнэлгээ, зам тээврийн осол, тээврийн хэрэгслийн засварын түүх, зөрчлийн тухай” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Жолоочийн даатгалын тухай хуулийн дараахь зүйл, хэсэг, заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

1/3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт:

“3.1.3.даатгуулагчийн итгэлийн түүх” гэж даатгагчаас даатгуулагчийн талаар хөтөлж байгаа мэдээллийг”

2/3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт:

“3.1.4.жолоочийн даатгалын нөхөн төлбөр /цаашид “нөхөн төлбөр” гэх/ гэж жолоочийн даатгалын тохиолдол үүссэн нөхцөлд даатгалын гэрээний дагуу даатгагчаас хохирогчид олгох мөнгөн хөрөнгө болон даатгалын гэрээгээр даатгалын нөхөн төлбөр олгох боломжгүй бол жолоочийн даатгалын сангаас хохирогчид олгох мөнгөн хөрөнгийг;”

3/ 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт:

“4.1.2. хохирогчийн хохирлыг барагдуулах нөхөн төлбөр олгох”

4/ 6 дугаар зүйлийн 2дахь хэсэг:

“6.2.Замын хөдөлгөөнд оролцдоггүй байлдааны болон мөрдөх алба, цагдаа тагнуул, зэвсэгт хүчин, хилийн цэрэг, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, онцгой байдлын тусгай зориулалттай байгууллагын тээврийн хэрэгсэлд энэ хууль хамаарахгүй.”

5/7 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

“7.1.Жолооч нь замын хөдөлгөөнд оролцох үедээ бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд учруулж болзошгүй хохирлыг барагдуулах зорилгоор энэ хуульд заасан нөхцөлийн дагуу даатгагчтай хариуцлагын даатгалын гэрээг бичгээр, эсхүл цахим хэлбэрээр байгуулна”

6/7 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

“7.2.Энэ хуулийн 7.1. дэх хэсэгт заасан хариуцлагын даатгалын гэрээг байгуулахын өмнө даатгуулагч батлагдсан маягтын дагуу бичгээр эсхүл цахим хэлбэрээр даатгагчид мэдүүлэг бөглөж өгнө.”

7/ 7 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:

“7.5.Улсын хилээр түр болон дамжин өнгөрөх автотээврийн хэрэгслээс бусад тохиолдолд жолоочийн даатгалын гэрээ нэг жил хүртэл хугацаанд хүчинтэй байх бөгөөд даатгуулагчаас даатгалын хураамж төлснөөр хүчин төгөлдөр болно.”

8/8 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

“8.1.Даатгалын гэрээ байгуулсан даруйд даатгагч нь гэрээ байгуулсныг гэрчлэх даатгалын баталгааг өгөх бөгөөд Жолоочийн даатгалын сангийн мэдээллийн нэгдсэн сангаас цахимаар олгосон мэдээллийг агуулсан дугаар нь даатгалын баталгаа болно.”

9/9 дүгээр зүйл

“9 дүгээр зүйл.Даатгалын үнэлгээний доод хэмжээ”

“9.1.1. “А”, “В” болон “Механизм” ангиллын тээврийн хэрэгслийн хувьд нэг хохирогчтой бол эд хөрөнгийн хохиролд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 16 дахин хүртэл, амь нас, эрүүл мэндийн хохиролд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 32 дахин хүртэл, нэгээс дээш хохирогчтой бол нийт хохирлын үнэлгээнд эзлэх хувиар тооцож хуваах бөгөөд эд хөрөнгийн хохиролд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 32 дахин хүртэл, амь нас эрүүл мэндийн хохиролд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 64 дахин хүртэл;”

“9.1.2. “С” болон “D” ангиллын тээврийн хэрэгслийн хувьд нэг хохирогчтой бол эд хөрөнгийн хохиролд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 32 дахин хүртэл, амь нас, эрүүл мэндийн хохиролд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 64 дахин хүртэл, нэгээс дээш хохирогчтой бол нийт хохирлын үнэлгээнд эзлэх хувиар тооцож хуваана.

“9.2.Даатгалын үнэлгээ нь энэ хуулийн 9.1-д заасан үнэлгээнээс өндөр байхаар даатгагч, даатгуулагч харилцан тохиролцсон бол тус давсан хэсэгт хураамжийн хэмжээг харилцан тохиролцож тогтоож болох бөгөөд энэ тохиолдолд даатгалын хураамжийн хэмжээг даатгалын гэрээгээр энэ хуульд зааснаас өөрөөр тогтоож болно.”

10/ 10 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

“10.1.Даатгалын суурь хураамжийн хэмжээг санхүүгийн зохицуулах хороо болон мэргэжлийн холбоодын төлөөлөл бүхий ажлын хэсэг 3 жил тутам шинэчлэх асуудлыг хэлэлцэж дүгнэлт гаргана.”

14/10 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

“10.2.Ажлын хэсгийн дүгнэлт гарснаас хойш 1 сарын дотор Санхүүгийн зохицуулах хорооны хурлаар батална.”

15/ 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт:

“12.1.3.даатгалуулагчид учирсан хохирол ”

16/13 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт:

“13.1.2.даатгалын тохиолдол гарсан талаар даатгагч, хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учирсан тохиолдолд цагдаагийн байгууллагад мэдэгдэх;”

17/15 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

“15.2.Даатгалын тохиолдлын талаарх мэдээллийг хүлээн авсан даруйд даатгагч, жолоочийн даатгалын сан нь даатгалын тохиолдол болсон газарт төлөөлөгчөө нэн даруй илгээх үүрэгтэй.”

18/16 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

“16.1.Даатгагч, жолоочийн даатгалын сангийн төлөөлөгч нь хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, даатгуулагч өргөдөл гаргаснаас хойш 3 хоногийн дотор даатгалын тохиолдлыг шалгах үүрэгтэй.”

19/16 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

“16.3.Даатгагч эсхүл даатгуулагч нь хохирлын үнэгээний талаар харилцан тохиролцоогүй бол даатгалын хохирол үнэлэгч томилон даатгалын тохиолдлыг шалгуулах хохирлын хэмжээг тогтоолгох зорилгоор тухайн өвтотээврийн хэрэгсэлд теникийн үзлэг хийлгэж болно.”

20/ 16 дугаар зүйлийн 6 дахь хэсэг:

“16.6.Даатгалын тохиолдлыг Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 10.1-т заасан зам тээврийн ослын бүртгэл, зам тээврийн ослын улмаас гэмтсэн, нас барсан хүний бүртгэлийг үндэслэн тогтооно.”

21/ 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг:

“19.1.Даатгагч, жолоочийн даатгалын сан нь хохирогчид олгох нөхөн төлбөрийн хэмжээг харилцан тохиролцож эсхүл даатгалын хохирол үнэлэгчийн дүгнэлт, тодорхойлолт, энэ хуулийн 17 дугаар зүйлд заасныг үндэслэн тогтооно.”

22/22 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

“22.2.Энэ хуулийн 22.1.1-д заасны дагуу төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээг Албан журмын даатгалын сангийн удирдах зөвлөлөөс гаргасан саналыг үндэслэн Санхүүгийн зохицуулах хороо жил бүр тогтооно.”

23/22 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:

“22.4.Жолоочийн даатгалын сангийн хөрөнгө үндсэн зорилгоо хэрэгжүүлэхэд хүрэлцэхгүй болсон тохиолдолд Албан журмы даатгалын сангийн удирдах зөвлөлийн шийдвэрээр жолоочийн даатгалын үйл ажиллагаа эрхлэгчдээс хөрөнгө татан төвлөрүүлж болно.”

24/24 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг:

“24.6.Мэдээллийн сангийн мэдээллийг ашиглуулах журам, үйлчилгээний хөлсний хэмжээг Албан журмын даатгалын сан тогтоох ба орлогыг нь мэдээллийн сангийн үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зарцуулна.”

25/27 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

“27.1.Жолоочийн даатгалтай холбоотой гарсан маргааныг Даатгалын тухай хуулийн 91 дүгээр зүйлд заасан журмаар шийдвэрлэнэ.”

3 дугаар зүйл. Жолоочийн даатгалын тухай хуулийн “Мэдээллийн сан, шуурхай алба” гэсэн Зургаадугаар бүлгийн нэрийн “шуурхай алба” гэснийг, 3 дугаар зүйлийн 3.1.8 заалт, 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсгийн “бичгээр” гэснийг, 8 дугаар зүйлийн 8.2-8.3 дахь хэсгүүдийг бүхэлд нь, 13 дугаар зүйлийн 13.1.4 дэх заалтыг бүхэлд нь, 13 дугаар зүйлийн 13.2.2 дахь заалт, 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэг, 14.2 дахь хэсгийн “шуурхай алба гэснийг, 16 дугаар зүйлийн 16.4 дэх хэсгийн “эсхүл даатгалын хохирол үнэлэгчийг томилоогүй бол” болон “Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 3.2.4-т заасан” гэснийг, 19 дүгээр зүйлийн 19.9 дэх хэсэг, 23 дугаар зүйлийн 23.1.3 дахь хэсгийн “...шуурхай алба...” гэснийг, 23 дугаар зүйлийн 23.3 дахь хэсгийг бүхэлд нь, 24 дүгээр зүйлийн 24.4 дэх хэсгийн “Даатгалын тухай хуулийн 12¹ дүгээр зүйлд заасан “Албан журмын даатгагчдын холбооны гишүүн” гэснийг, 25 дугаар зүйлийг бүхэлд нь тус тус хассугай.

ГАРЫН ҮСЭГ